



ЗАХИРАЛ

БАТЛАВ

Ц.БАТБОЛД

2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр

## **АМГАЛАН АМАРЖИХ ГАЗАР ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ ХҮНИЙ НӨӨЦИЙГ 2022-2026 ОНД ХӨГЖҮҮЛЭХ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨР**

Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь цаашид 2022-2026 онд баримтлах “Хүний нөөцийн хөгжлийн баримт бичиг”-ийг батлан хэрэгжүүлж байна.

### **Нэг. Хөтөлбөрийн зорилго**

Энэхүү хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн зорилго нь Амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн эрхэм зорилго, үйл ажиллагааны стратеги зорилгыг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийг төлөвлөх, бүрдүүлэх, сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, өнөөгийн хүний нөөцийг үнэлэх, ирээдүйн хэрэгцээг тодорхойлох, түүнд хүрэхэд учирч болох эрсдэлийг тооцох, гүйцэтгэлд суурилсан бүтээлч байдал, чадварлаг, тогтвор суурьшилтай боловсон хүчин бий болгохын тулд албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх, ажилтан, албан хаагчид болон удирдах албан тушаалтнуудын харилцаа холбоог бэхжүүлэх, албан хаагчдыг давтан мэргэшүүлэн сургах, чадавхжуулах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангагдсан, эрүүл аюулгүй ажлын байр бүрдүүлэхэд оршино.

### **Хоёр. Зорилт**

- Байгууллагын удирдлага, ажилтнуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх
- Эмнэлгийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагын тогтолцоог сайжруулах
- Амаржих газрын ажилтнуудын нийгмийн баталгааг хангаж эрмэлзлийг нэмэгдүүлэх дэмжлэг орчинг бүрдүүлэх.
- Амаржих газрын хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох
- Хүний нөөцийн бодлогыг ил тод, нээлттэй байдлыг хангах
- Хүний нөөцийг хэрэгжүүлэх чиглэлээр гадаад дотоодын хамтын ажиллагааг хөгжүүлэх

### ***Байгууллагын удирдлага, ажилтнуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилтын хүрээнд:***

- Амаржих газрын удирдлага, ажилтнуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх нээлттэй хэлэлцүүлэг, санал бодлыг хүлээн авах үйл ажиллагааг өрнүүлэх.